



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР

Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ



2022 оны 5 дугаар сарын байдлаар

Мөрөн сум

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 5 сарын байдлаар 903 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 180 тохиолдол буюу 16,6%-иар буурсан байна. Төрөлт Баянзүрх, Бүрэнтогтох, Галт, Их-Уул, Рашаант, Ханх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумдад өсч бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 71,4% байна.




ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 5 сарын байдлаар нийт 903 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 182 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 3,2 хувь /29/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 97,3 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2022 оны эхний 5 сард нийт 26566 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0,1 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 36,0 хувь нь А амин дэм, 60,0 хувь нь Д амин дэм, 7,8 хувь нь олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн байна.

НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ


Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 5 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдсэн нь 2021 оны мөн үеэс 7 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 14.4 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 46.2 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд 6.6 байна. Нийт 10 тохиолдол буюу 76.9 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 7 нь эрэгтэй хүүхэд байна.

Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2022 оны эхний 5 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан байна. 1000 амьд төрөлтөнд 3,3 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл тус тус осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдол бүртгэгдсэн байна.



НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны эхний 5 сарын байдлаар 320 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 30 тохиолдолоор өссөн байна. Нийт нас баралтын 21,3 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 30,9 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 49 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдолоор өссөн, нийт нас баралтын 15,3 хувийг эзэлж, 10000 хүн амд 3,6 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 76 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор өсч 10000 хүн амд 5,6 ногдож байна.



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/



1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 8.8
2. Хавдар-5.6
3. Гадны шалтгаант өвчлөл- 3.6
4. Амьсгалын тогтолцооны өвчин-1.7
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-1.2



Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 5 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 431, эсийн шинжилгээ 1826 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 46 нас баралт буюу 56.5% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү 1 бүртгэгдсэн байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 26 тохиолдол байна.

АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ


Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 5 сарын байдлаар амбулаторид нийт 200375 үзлэг хийгдсэнээс 25.6 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 57.8 хувийг өвчний учир амбулаторид, 9.4 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 4.9 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2,4 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.



ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 952 жирэмсэн эмэгтэйчүүдээс 89.7 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 95.2 хувь нь хамрагдаж, 1.1 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 5 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 94.5 хувийг, тэмбүү, ХДХВ илрүүлэх шинжилгээнд 97.0 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-32, трихомониаз-4, тэмбүү-19 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.

Жирэмсэний эрт хяналтын хувь,
2022 оны эхний 5 сарын байдлаар



ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2022 оны эхний 5 сарын байдлаар халдварт бус өвчлөл 48076 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6493 тохиолдлоор буурсан байна. 10000 хүн амд 3513.2 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 541 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1,1 хувийг эзэлж, 10000 хүн амд 39.5 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 604.9
2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 574.5
3. Нүд ба түүний дайврын тогтолцооны өвчин-318.5
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-241.0
5. Мэдрэлийн эрхтэн тогтолцооны өвчин- 202.0


Стационарт нийт 14429 хүн хэвтэж эмчлүүлсэн ба дундаж ор хоног 6.9, орны эргэлт 15.1, орны фонд ашиглалт 104.1, фонд ашиглалтын хувь 75.7 байна. Алаг-Эрдэнэ, Арбулаг, Бүрэнтогтох, Тариалан, Тосонцэнгэл, Түнэл, Цагаан-Үүр, Цэцэрлэг сумд, Хувийн эмнэлэг орны фонд ашиглалт аймгийн дунджаас дээгүүр, бусад газруудад доогуур хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 5 сарын байдлаар нийт 8977 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 17,4 хувь /1562/ нь алсын дуудлага, 2,6 хувь /229/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 59.8 дуудлага, АНЭ 21,7 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.


ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны эхний 5 сарын байдлаар Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 9375 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 10.7 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 40.7% эрэгтэй, 59.3% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 1091 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 286 буюу 26,2% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 9448 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 10.8 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 40.4% эрэгтэй, 59.6% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 320 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 26 буюу 8.1% нь онош баталгаажсан байна.


Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр



Эрт илрүүлэг үзлэгийн хувь, нэгжээр





ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 29013 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 32.6 хувь
- Өвчний учир үзлэг 37.2 хувь
- Диспансерийн хяналт 22.6 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 7.1 хувь
- Гэрийн дуудлага 0.6 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 3715 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 16,4 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 334 жирэмсэн эмэгтэйдгээс 85.3 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 95 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 27 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 31, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдсэнээс АНЭ-т 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 14255 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 1.9 хувь
- Диспансерийн хяналт 2,3 хувь
- Өвчний учир үзлэг 95.8 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 4324 хүн эмчлэгдэж, 32501 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.5 орны эргэлт 15.6 ба орны фонд ашиглалт 117.3 байна. Нийт 3 халдварт бус өвчний тохиолдол бүртгэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН


Аймгийн хэмжээнд эхний 5 сарын байдлаар 3875 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 283.2 ногдож байна. 2021 оны мөн үед 490 тохиолдол, 10000 хүн амд 36.3 ногдож байжээ. 10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Цагаан-Үүр, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Мөрөн суманд аймгийн дунджаас өндөр байна.

Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 13.1 хувь, сүрьеэ 0,8 хувь, амьсгалын замын өвчин 0.7 хувь, цусан халдвар 0.1 хувь, гэдэсний халдварт өвчин 0.4, арьс салтстаар халдварлах халдвар 0.1, Зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 0,3 хувь, Ковид-19 халдвар 84,5 хувийг тус тус эзэлж байна.

ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт цочмог халдварт өвчний 3368 тохиолдлоос:

- Гар хөл амны өвчин 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Халдварын гаралтай суулгалт 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 6 тохиолдлоор
- Ёлом 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Гахайн хавдар 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Цусан суулга 10 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 12 тохиолдлоор тус тус буурч
- Сүрьеэ 30 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 6 тохиолдлоор
- Хоолны хордлого 6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор
- Хепатит В 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит С 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Салхинцэцэг 27 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор
- Хачигт риккетсиоз 10 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор
- Ковид-19 3279 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3182 тохиолдлоор тус тус өсч
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.




ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ


1. 2022 оны эхний 5 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 3372 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс цэврүүт тууралт 0,7 хувь (22), цусархаг суулгалт 0,3 хувь (9), шарлалттай 0,1 хувь (4), халууралт тууралт 1,3 хувь (43), хоолны хордлогот халдвар 0,2 хувь (6), шинэ вирусын халдвар 97,5 хувь (3288) тус тус бүртгэгдсэн байна.

2. Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/


Халдварт өвчний хам шинж, сэжигтэй өвөрмөц тохиолдол,
харьяалалаараа



Шинэ вирусийн халдварын сэжигтэй тохиолдол,
мэдээлэгдсэн долоо хоног



Шинэ вирусийн халдварын сэжигтэй тохиолдол
/2022 оны эхний 21-р долоо хоног/



Age Group	Percentage
65+	8.76
45-64	26.03
25-44	38.05
15-24	8.15
10-14	7.15
5-9	5.93
1-4	4.53
0-11c	1.4


Халдварын үйлдвэрлэл	Хувь
Шинэ вирусийн халдварын сэжигтэй	97.51
Халууралт тууралт	1.28
Цэврүүт тууралт	0.65
Цусархаг суулгалт	0.27
Цочмог шарлалт	0.12
Хоолны хордлогот халдвар	0.18

2022 թվականի 5 դեկտեմբերի առավոտյան ժամին ընդհանուր առմամբ 15592 օրվա ընթացքում հավաքագրվել է 10000 օրվա ընթացքում 1155,2 միլիարդ ռուբլի: Օգտագործվել է 2472 օրվա ընթացքում հավաքագրված 10000 օրվա ընթացքում 184,3 միլիարդ ռուբլի:


The chart displays the weekly death toll per 100,000 population for 2021 and 2022. The 2022 data shows a sharp rise starting in week 2, peaking in week 12, and then gradually declining. The 2021 data shows a much lower and more stable death toll throughout the year.

Week	2021	2022
1	7.7	20.4
2	7.4	22.8
3	7.4	70
4	10.1	76.7
5	9.4	32.7
6	5.7	64.9
7	9.5	49.2
8	11.6	64.2
9	13.3	56.5
10	16.8	70.1
11	16.8	72.5
12	15	111.2
13	8.1	110.8
14	6.6	73.9
15	6.2	53.2
16	6.9	35.6
17	6.6	27.9
18	3.4	27.1
19	8.3	27.8
20	3.3	35.4
21	4.4	54


Томуу томуу төст өвчин, долоо хоногоор



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)





АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар)



БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 13,1% (507) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 63,5% (311) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Тэмбүү 72 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 16 тохиолдлоор ,
- Трихомониаз 19 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 29 тохиолдлоор тус тус буурч
- Гонококк халдвар 416 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 241 тохиолдлоор өссөн байна.



Хянасан:
Дүгнэлт хийсэн:

Эрүүл мэндийн газрын дарга М.Үүрийнбаяр
Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
П.Баярмаа